



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 12 он 04
сарын 29 өдөр

Дугаар 31-1/71

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224000971



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2024 оны дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар ХХ/969

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

"II.ХЭЛЭЛЦСЭН нь: "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.04.29 № 1/2488
танай 2022.04.29-ны № 01/368 -т

**ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ
Б.ЖАВХЛАН ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603320 А5 Файл.2022



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2022-04-29 № 01/2749

танай _____-ны № _____-т

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ДЭД САЙД С.НАРАНЦОГТ ТАНАА

Монгол Улсын Их Хурлын "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай" тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.



Б.ЖАВХЛАН

9761000658



“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэгт “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газрын санаачлахаар Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг зөвхөн Засгийн газар санаачилна” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт “Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ” гэж тус тус заасан.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн төсөлтэй уялдуулан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.1-д заасныг удирдлага болгон Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 5 заалт, 1 хавсралттай байх бөгөөд тогтоолын төслийн хавсралтаар батлагдах “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний төслийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 119 дүгээр тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасан “Улсын Хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө” боловсруулах загвар маягтын дагуу дэс дугаар, бодлогын үндэслэл, зорилт, арга хэмжээ, үр дүнгийн шалгуур үзүүлэлт, суурь болон

зорилтот түвшин, 2023 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, хөрөнгийн эх үүсвэр, үндсэн хариуцагч, хамтран хариуцагч зэргийг тусган боловсруулна.

Тогтоолын төслийн 1 дэх заалтаар Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг батлах, 2 дахь заалтаар Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвөөс санхүүжих шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах, 3 дахь заалтаар Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгах, 4 дэх заалтаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгох, 5 дахь заалтаар тогтоолыг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө” батлагдсанаар хүний хөгжлийн бодлогын зорилт хэрэгжиж хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, ажлын байр хадгалагдаж, иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчин сайжирч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

- Эдийн засгийн бодлогын зорилт хэрэгжих тул бодит өсөлтийг дэмжих төсөл, арга хэмжээ хэрэгжих тул макро эдийн засгийн тогтвортой байдал хадгалагдаж, эдийн засгийн цар хүрээг тэлэх боломж бүрдэнэ.

- Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлогын зорилт хэрэгжих тул иргэдэд үзүүлэх үйлчилгээ цахимжиж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөл бүрдэнэ.

- Ногоон хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах бодлогын зорилт хэрэгжих тул байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах боломж бүрдэнэ.

- Нийслэл, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилт хэрэгжих тул хот суурин газрын орон сууцны хангамж нэмэгдэж, амьдрах таатай орчин бүрдэж, бүс, орон нутаг, хөдөөгийн дэд бүтэц сайжирна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн “Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй тус тус уялдуулан боловсруулав.

“Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний төсөлд төрийн захиргааны төв, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны зорилт, арга хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар нийт 23.5 их наяд төгрөгийн 643 арга хэмжээний санал ирүүлснээс Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон бусад хөрөнгийн эх үүсвэрийн нөөц боломжтой уялдуулан нийтдээ 15 их наяд 137 тэрбум 7 сая төгрөгийн санхүүжилт бүхий 18 зорилт 75 арга хэмжээг тусгалаа.

Үүнээс улсын төсвийн хөрөнгөөр 1 их наяд 887 тэрбум 663 сая төгрөг, гадаадын зээл, тусламжаар 1 их наяд 646 тэрбум 452 сая төгрөг, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар 6 их наяд 34 тэрбум 196 сая төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэлээр 4 их наяд 197 тэрбум 236 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 951 тэрбум 458 сая төгрөгийн санхүүжилт бүхий арга хэмжээг төлөвлөсөн болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны дугаар
сарын-ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
3. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс жигд ханган зохион байгуулж, түүний биелэлтийг бүтэн жилээр гаргаж, Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.
4. "Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.
5. Энэ тогтоолыг 2023 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ

№	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		2023 онд шаардлагатай хөрөнгө		Үндсэн хариуцагч	Хамтран хариуцагч
				Суурь түвшин /2021 он/	Зорилтот түвшин /2023 он/	Санхүүжилт йн хэмжээ /сая.төг/	Санхүүжилт йн эх үүсвэр		
0	1	2	3	4	5	6	7	8	9
Бүлэг 1.Хүний хөгжлийн бодлого									
Зорилго 1.1.Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрийг тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.									
1.1.1	МУХТЖҮЧ-2.1.7, ЗГҮАХ-2.3.8	Багшийн чадварыг сайжруулж, үнэлэмжийг дээшлүүлэх "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	Боловсрол, шинжлэх ухааны яам /Цаашид БШУЯ/	
1.1.2	МУХТЖҮЧ-2.1.2, ЗГҮАХ-2.3.3	Суралцагчийн сургалтын ахиц дэвшлийн үнэлгээг хийж, ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулах	Бага, дунд боловсролын чанарын дундаж үнэлгээ, хувиар	41	55	-	Улсын төсөв	БШУЯ	
			Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын үнэлгээ (PISA)-нд тулгуурлан зөвлөмж боловсруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	БШУЯ	

1.1.3	МУХТЖҮЧ- 2.1.3, ЗГҮАХ- 2.3.4	Сургалтын хөтөлбөрт шинжилгээ монгол хандлага, хүмүүжил, төлөвшилд нийцсэн түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга агуулгаар баяжуулсан сургалтын хөтөлбөр боловсруулах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	БШУЯ	Соёлын яам /Цаашид СоЯ/
1.1.4	МУХТЖҮЧ- 2.1.1, ЗГҮАХ- 2.3.2	Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдах настай хүүхдийн хамран сургалтын хувь	-	88.5	-	Улсын төсөв	БШУЯ	
1.1.5	МУХТЖҮЧ- 2.1.8, ЗГҮАХ- 2.3.9	Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулах	Ашиглалтад орох сургуулийн тоо Ашиглалтад орох цэцэрлэгийн тоо	17 сургууль 28 цэцэрлэг	36 сургууль 48 цэцэрлэг	279,713.8	Улсын төсөв	БШУЯ	Барилга, хот байгуулал- тын яам /Цаашид БХБЯ/

1.1.6	МУХТЖҮЧ- 2.1.8, ЗГҮАХ- 2.3.4, 2.3.9, 2.3.11	Суралцагчид тав тухтай орчинд суралцаж, бие бялдгар, авьяас чадвараа хөгжүүлэх орчныг бүрдүүлэх	Сургууль, цэцэрлэгийг төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ажлын явц, хувиар	-	100	10,880.0	Улсын төсөв	БШУЯ	
			Ашиглалтад оруулах дотуур байрны тоо	-	17	34,136.2	Улсын төсөв	БШУЯ	БХБЯ
			Шинээр барих болон өргөтгөх спорт заалны тоо	-	19	17,216.6	Улсын төсөв	БШУЯ	БХБЯ
			Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдах суралцагчдын хувь	-	50	-	Улсын төсөв	БШУЯ	
1.1.7	МУХТЖҮЧ- 2.1.9, ЗГҮАХ- 2.3.10	Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл стандартыг дээшлүүлж, "Үдийн хөтөлбөрт хоол" дунд сурагчдыг хамруулах	Шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах цэцэрлэг, дотуур байрны тоо	-	139 сургууль 83 цэцэрлэг 112 дотуур байр	-	Дотоод хөрөнгө оруулалт	БШУЯ	БХБЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар /Цаашид АНЗДТГ/
			Стандартад нийцсэн хоолны газартай сургуулийн эзлэх хувь	25	100	-	Улсын төсөв	БШУЯ	Эрүүл мэндийн яам /Цаашид ЭМЯ/
			"Үдийн хоол" хөтөлбөрт хамрагдах дунд сурагчдын тоо	-	194,833	-	Улсын төсөв	БШУЯ	

1.1.8	МУХТЖҮЧ- 2.1.5, ЗГҮАХ- 1.1.11, 2.3.8	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч, багш мэргэжлээр суралцагчдад сурлагын амжилттай нь уялдуулан тэтгэлэг олгох	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	БШУЯ	
Зорилго 1.2. Судалгаа хөгжүүлэлт, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, судалгааны ажлын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлнэ.									
1.2.1	МУХТЖҮЧ- 2.4.1, ЗГҮАХ- 2.4.1	Шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгааны ажлыг дэмжиж, шинэ мэдлэг, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, болгон үйлчилгээ хэрэглээнд нэвтрүүлэх	Эрдэм шинжилгээ, судалгаанд зардал, ДНБ-д эзлэх хувиар	0.1	0.18	-	Улсын төсөв	БШУЯ	Сангийн яам /Цаашид СЯ/
1.2.2	МУХТЖҮЧ- 2.4.3, ЗГҮАХ- 2.4.2	Эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл байдлыг хангах, уялдаа холбоог сайжруулах	Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын барилгын ажлын явц, хувиар	-	100	50,378.8	Улсын төсөв	БШУЯ	
Зорилго 1.3. Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.									
1.3.1	МУХТЖҮЧ- 2.2.2,	Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт	"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга	-	30	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ

ЗГҮАХ-2.1.1	илрүүлэх, амьдралын маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн хэмжээг хэрэгжүүлэх	хэмжээний хэрэгжилт, хувиар "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний хэрэгжилт, хувиар "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний хэрэгжилт, хувиар "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулах ажлын явц хувиар "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний хэрэгжилт, хувиар "Хавдрын эсрэг" арга хэмжээний хэрэгжилт, хувиар Сүрьеэгийн эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар	-	50	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			-	50	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			-	50	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			-	30	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			-	50	-	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			-	20	16,500.0	Улсын төсөв	ЭМЯ	СЯ
			-	10	10,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
			-	10	40,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
			46	80	5,600.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
1.3.2	МУХТЖҮЧ-2.2.3, ЗГҮАХ-1.1.3, 2.1.3	Орчин үеийн стандартад нийцсэн эмнэлгийн тоог нэмэгдүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах						

1.3.3	МУХТЖҮЧ-2.2.6, ЗГҮАХ-2.1.6	Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулж, нэгдсэн сан бүхий мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор II-ын салбар барилгын ажлын явц, хувиар	-	10	60,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
1.3.4	МУХТЖҮЧ-2.2.2, ЗГҮАХ-2.1.14	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг орчин үеийн	Хавдар судлалын үндэсний төвийн II-ын салбар барилгын ажлын явц, хувиар	-	10	30,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
			Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлгийн барилгын ажлын явц, хувиар	-	20	5,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭМЯ	СЯ
			Шинээр барих болон өргөтгөх нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо	-	40	113,624.5	Улсын төсөв	ЭМЯ	АНЗДТГ
			Өвчний хяналт, зохицуулалтын төвийн барилгын ажлын явц, хувиар	-	100	1,500.0	Улсын төсөв	ЭМЯ	СЯ
			Мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлэх ажлын явц, хувиар	30	100	18,138.0	Гадаадын зээл, тусламж	ЭМЯ	
			Телемедицин нэвтрэх мэндийн эрүүл байгууллагын тоо	3	35	-	Улсын төсөв	ЭМЯ	СЯ
			Ариун цэврийн байгууламжийг шинэчлэх сумын эрүүл мэндийн төвийн тоо	15	60	11,160.0	Улсын төсөв	ЭМЯ	

		стандартад нийцүүлэн шинэчлэх										
Зорилго 1.4.Хүн амын эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг дэмжиж, амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.												
1.4.1	МУХТЖҮЧ- 3.5.2, ЗГҮАХ- 2.2.3	Олон улсын жишигт нийцсэн спорт цогцолборыг ашиглалтад оруулж, хүн амын идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих	Ашиглалтад орох спортын ордон болон цогцолборын тоо	-	14	75,320.9	Улсын төсөв	Биеийн тамир, спортын улсын хороо	НЗДТГ			
1.4.2	МУХТЖҮЧ- 2.3.2, ЗГҮАХ- 2.5.8	Хүүхдийн хөгжлийг дэмжих "Найрамдал-2" зуслангийн цогцолбор барих	Барилгын ажлын явц, хувиар	-	40	24,000.0	Улсын төсөв	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам /Цаашид ХНХЯ/	СЯ			
1.4.3	МУХТЖҮЧ- 1.2.4, ЗГҮАХ- 2.5.8	Ахмад настан, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төвүүдийг байгуулах	Ашиглалтад орох хөгжлийн төвийн тоо	-	10	23,632.2	Улсын төсөв	ХНХЯ				
Зорилго 1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, нийгмийн хамгааллыг зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.												
1.5.1	МУХТЖҮЧ- 2.6.2, ЗГҮАХ- 2.5.4	Салбар тус бүрийн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх	Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, тэргүүлэх чиглэл, эрэлт, хэрэгцээний чиглэлээр хийх судалгааны тоо	-	3	-	Улсын төсөв	ХНХЯ	БШУЯ			
			Ажил мэргэжлийн эрэлтэд суурилан сургалтын хөтөлбөрийг шинэчлэх арга	-	100	-	Улсын төсөв	БШУЯ	ХНХЯ			

				хэмжээний хэрэгжилт, хувиар								
1.5.2	МУХТЖҮЧ- 2.3.4, 2.6.2, ЗГҮАХ- 2.3.12, 2.5.8, 2.5.9	Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих		Орлого багатай иргэдэд чиглэсэн мэргэжлийн ур чадвар олгох, мэргэшүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХНХЯ	СЯ, АНЗДТГ		
				Залууст ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрт бэлтгэх, ажлын байранд дадлагажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХНХЯ			
				Мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийн барилгын ажлын явц, хувиар	20	100	16,788.7	Гадаадын зээл, тусламж	БШУЯ			
				Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх Хөдөлмөр эрхлэлтийн төвийн барилгын ажлын явц, хувиар	-	50	17,279.5	Гадаадын зээл, тусламж	ХНХЯ	СЯ		

			Насан туршдаа суралцах боломжийг дэмжих, бие даан олж авсан мэдлэг, ур чадварыг баталгаажуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	БШУЯ	
1.5.3	МУХТЖҮЧ-3.3.2, ЗГҮАХ-3.3.13	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд ажлын байр бий болгох, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Дэмжлэгт хамрагдах жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	12	400	-	Улсын төсөв	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам /Цаашид ХХААХҮЯ/	СЯ
1.5.4	МУХТЖҮЧ-4.5.2, ЗГҮАХ-3.3.14	Үндэсний үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, чадавхжуулах "Үндэсний ханган нийлүүлэлт" хөтөлбөр хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	Эдийн засаг, хөгжлийн яам /Цаашид ЭЗХЯ/	
1.5.5	МУХТЖҮЧ-3.1.5, ЗГҮАХ-2.5.5	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоох	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХНХЯ	СЯ
Зорилго 1.6.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.									
1.6.1	МУХТЖҮЧ-1.2.1,	Үндэсний бахархал, өв соёлыг	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл-1" арга	50	80	-	Улсын төсөв	СоЯ	АНЗДТГ

1.5.1, 4.2.4, ЗГҮАХ- 2.6.2, 4.5.10	сурталчлан таниулж, үндэсний онцлогийг агуулсан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих	хэмжээний хэрэгжилт, хувиар Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолборын барилгын ажлын явц, хувиар	50	100	4,000.0	Улсын төсөв	СоЯ	СЯ, БХБЯ
		"Дэлхийн Монголчууд-II" цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	70	-	Улсын төсөв	Гадаад харилцааны яам /Цаашид ГХЯ/	СоЯ, БШУЯ
		Ашиглалтад орох соёл урлагийн байгууламж, музей болон номын сангийн тоо	-	15	71,085.7	Улсын төсөв	СоЯ	АНЗДТГ, БХБЯ, СЯ
Бүлэг 2.Эдийн засгийн бодлого								
Зорилго 2.1.Эдийн засгийн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг хангана.								
2.1.1	МУХТЖҮЧ- 4.1.5, ЗГҮАХ- 3.1.1	Инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах мөнгөний бодлого хэрэгжүүлэх	Инфляцын хувиар	13.4	6±2	-	Улсын төсөв	Монголбанк СЯ
2.1.2	МУХТЖҮЧ- 4.1.1, 4.1.2, ЗГҮАХ- 3.1.2, 3.1.9	Засгийн газрын өрийн хэмжээг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хязгаараас хэтрүүлэхгүй байхад чиглэсэн төсвийн бодлого хэрэгжүүлэх	Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэх Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь	50.7 60.7 5.1	65 хувиас хэтрэхгүй 60 хувиас хэтрэхгүй 3.6	- - -	Улсын төсөв Улсын төсөв Улсын төсөв	СЯ СЯ СЯ

2.1.3	МУХТЖУЧ-4.1.2, ЗГҮАХ-4.3.12	Санхүүгийн зээлийг өргөжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо /Цаашид СЗХ/	
2.1.4	МУХТЖУЧ-4.1.2, ЗГҮАХ-5.1.12	Тогтвортой санхүүжилт болон ногоон төслүүдийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	Монголбанк, СЗХ	БОАЖЯ
Зорилго 2.2. Боомтын сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэн эдийн засгийн өсөлтийг тэтгэж, экспортыг нэмэгдүүлнэ.									
2.2.1	МУХТЖУЧ-8.1.5, ЗГҮАХ-3.1.18, 4.3.1	Боомтуудын зорчигч болон ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх дэд бүтэц, барилга байгууламж барих	Хилийн боомтуудыг орчин үеийн бүхий технологи хяналт шалгалтын тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувиар	-	100	63,595.9	Улсын төсөв	СЯ	
			Шивээхүрэн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын явц, хувиар	-	100	70,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	СЯ	
			Замын-Үүд эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн дэд бүтэц, барилгын ажлын явц, хувиар	-	100	12,523.4	Гадаадын зээл, тусламж	ЭЗХЯ	БХБЯ
			Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан шинээр суурилуулах ухаалаг гарцын тоо	Чингис хаан боомт-12	Алтанбул аг-8, Замын-Үүд-8, Бичигт-4, Боршоо-4	-	Улсын төсөв	Хууль зүй, дотоод хэргийн яам /Цаашид ХЗДХЯ/	

2.2.2	МУХТЖҮЧ- 8.1.2, ЗГҮАХ- 3.6.1	Боомтуудыг холбох темер зам болон авто зам барих хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Тавантолгой- Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" боомт хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар	-	50	232,526.5	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Зам, тээврийн хөгжлийн яам /Цаашид ЗТХЯ/	СЯ, ЭЗХЯ
			Баруун-Урт-Бичигт чиглэлийн 277.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	-	30	332.7	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ, ЭЗХЯ
			Тавантолгой- Манлай-Ханги чиглэлийн 478 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар	17	100	474,154.8	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ, ЭЗХЯ
			Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар- Зүүнбүрэн- Цагааннуур-Түшиг- Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км авто замын барилгын ажлын явц, хувиар	18	100	238,600.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ, ЭЗХЯ
			Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын явц, хувиар	-	30	33,844.3	Улсын төсөв	ЗТХЯ	СЯ

			Тавантолгой- Гашуунсухайт чиглэлийн 250 км тусгай зориулалтын авто замын барилгын ажлын явц, хувиар	24	100	890,320.7	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ, ЭЗХЯ
			Баруун босоо чиглэлийн төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	22,750.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ
			Хөөт-Бичигт чиглэлийн 234.1 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	36,360.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	
			Хөөт-Чойбалсан чиглэлийн 192 км төмөр замын төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	75,600.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ
Зорилго 2.3.Эрчим хүчний сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд эрчим хүчний найдвартай, тогтвортой эх үүсвэр, дамжуулах, түгээх сүлжээг шинээр барьж байгуулна.									
2.3.1	МУХТЖҮЧ- 4.2.7, ЗГҮАХ- 3.5.1	Эрчим хүчний эх үүсвэр, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх	Тавантолгойн 450 МВт-ын цахилгаан станц, холбогдох дэд бүтцийг байгуулах барилгын ажлын явц, хувиар	-	20	142,500.0	Дотоод хөрөнгө оруулалт	Эрчим хүчний яам /Цаашид ЭХЯ/	СЯ
			Чойбалсангийн дулааны цахилгаан станцын хүчин чадлыг өргөтгөх	58	100	15,708.0	Монгол Улсын Хөгжлийн банк	ЭХЯ	

						барилгын ажлын явц, хувиар	-	80	35,750.0	Монгол Улсын Хөгжлийн банк	ЭХЯ		
						Амгалангийн станцыг дулааны барилгын өргөтгөл ажлын явц, хувиар							
						Багануурын станцын цахилгаан барилгын ажлын явц, хувиар	5	40	611,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭХЯ		
						Дулааны II цахилгаан станцын дэд бүцийг түшиглэн хийн цахилгаан станц барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	85,380.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭХЯ		
						Дулааны III цахилгаан станцыг 325 МВт-аар өргөтгөл төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	146,740.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭХЯ		
						Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй дулаан, цахилгааны хэрэгцээг хангах шинэ эх үүсвэр байгуулах төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	750.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭХЯ		СЯ

			Төвлөрсөн хот, сум, суурин газарт эрчим хүчний эх үүсвэр шинээр барих, өргөтгөх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	157,165.7	Улсын төсөв	ЭХЯ	
2.3.2	МУХТЖҮЧ-4.2.8, ЗГҮАХ-3.5.1, 3.5.6	Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах цэвэр эрчим хүчний ногоон төслүүдийг хэрэгжүүлэх	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилгын ажлын явц, хувиар	-	20	115,000.0	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
			160 МВт-ц багтаамжтай цахилгаан цэнэг хураагуурын станц барих ажлын явц, хувиар	10	100	45,000.0	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
			Ашиглалтад орох сэргээгдэх эрчим хүчний 10 МВт-ын станцын тоо	-	3	42,504.2	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
2.3.3	МУХТЖҮЧ-4.2.8, ЗГҮАХ-3.1.17, 3.5.43.5.4	Цахилгаан дамжуулах агаарын шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэн алдагдлыг бууруулж, суурин газруудыг холбох	Алтанбулаг чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн 35 кВт-ын цахилгаан дамжуулах шугам барих ажлын явц, хувиар	-	100	7,317.1	Улсын төсөв	ЭЗХЯ	СЯ
			Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастайн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлын явц, хувиар	-	30	180,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЭХЯ	СЯ

			Цахилгаан түгээх сүлжээний алдагдлыг бууруулах "Эрчим хүчний төсөл-2" төслийн хэрэгжилт, хувиар	70	100	22,694.3	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
			Төвийн цахилгаан дамжуулах, түгээх сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар	8	60	13,000.0	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
			Шинээр 10 аймгийн төвд дулааны станц, дулааны шугам сүлжээ, дулаан түгээх төв барих ажлын явц, хувиар	15	70	83,000.0	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
2.3.4	МУХТЖҮЧ-4.2.12, ЗГҮАХ-3.5.3	Дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Хан-Уул, Баянгол дүүрэгт хэрэгжих "Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах төсөл"-ийн хэрэгжилт, хувиар	10	60	31,000.0	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
			Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол дүүрэгт хэрэгжих "Улаанбаатарын дулаан хангамж төсөл"-ийн хэрэгжилт, хувиар	30	70	22,811.5	Гадаадын зээл, тусламж	ЭХЯ	СЯ
Зорилго 2.4.Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.									

2.4.1	МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.2.7, 3.2.8	Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг түүхий эдийг боловсруулах хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх	Газрын боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	50	90	200,000.0	Гадаадын зээл, тусламж	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам /Цаашид УУХҮЯ/	
			Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	50	90	330,000.0	Гадаад хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			"Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн барилгын явц, хувиар	-	75	912,000.0	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, хувиар	-	45.4	656,177.5	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийх барилгын ажлын явц, хувиар	69.4	100	139,020.4	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" барих ажлын явц, хувиар	-	100	133,663.0	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ	

			"Эрдэнэт ТӨҮГ-ыг зэсийн боловсруулах үйлдвэр барих ажлын явц, хувиар"	-	50	146,556.0	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			"Эрдэнэт ТӨҮГ-ыг исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр барих ажлын явц, хувиар"	-	100	167,371.0	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
2.4.2	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэх ажлын явц, хувиар	7	21	587,200.0	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
			Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар	3	43				
			Нүүрс ачилтын төв нэгдсэн байгуулах ажлын явц, хувиар	28	80				
			Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажлын явц, хувиар	10	80				
2.4.3	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	78	89	2,225,850.0	Гадаад хөрөнгө оруулалт	УУХҮЯ	
2.4.4	МУХТЖҮЧ-3.2.4, ЗГҮАХ-3.7.13	Арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн түүхий эдээ дотооддоо	Ашиглалтад орох үйлдвэрийн тоо	-	7	86,894.5	Дотоод хөрөнгө оруулалт	БХБЯ	

		Үйлдвэрлэх барилгын материалын үйлдвэрүүд барих		Геологийн 1:50000-ны масштабны зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	41.9	46	-	Улсын төсөв	УУХҮЯ	Үндэсний геологийн алба /Цаашид УГА/
				Геологийн 1:25000-ны масштабны зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	-	0.1	-	Улсын төсөв	УУХҮЯ	УГА
				Геологийн 1:200000-ны масштабны иж бүрдэл зураг хийх талбайн хэмжээ, хувиар	68	100	-	Улсын төсөв	УУХҮЯ	УГА
2.4.5	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.3	Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах		Агаарын геофизикийн 1:200000-ны масштабны соронзон судалгаа бүхий нутаг дэвсгэрийн хэмжээ, хувиар	65	68.1	-	Улсын төсөв	УУХҮЯ	УГА
				Геологийн зураглалыг төрөлжүүлж, шинээр болон үргэлжлүүлэн хийх судалгааны ажлын тоо	15	24	-	Улсын төсөв	УУХҮЯ	УГА
				Мэдээллийн баяжуулалт хийж, үйлчилгээг цахимжуулах гео мэдээллийн нэгдсэн сангийн тоо	-	3	-	Улсын төсөв	УУХҮЯ	УГА

Зорилго 2.5.Хөдөө аж ахуйн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.									
2.5.1	МУХТЖҮЧ- 4.2.4, ЗГҮАХ- 3.3.10	Малын гаралтай түүхий боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулах	Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	10	100	13,430.0	Улсын төсөв	ХХААХҮЯ	АЗДТГ, "Шинэ Ховд" баруун бүсийн хөгжлийн корпорац ОНӨААТҮГ
			"Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	-	70	107,000.0	Гадаад хөрөнгө оруулалт	ХХААХҮЯ	АЗДТГ, Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт ТӨХХК
2.5.2	МУХТЖҮЧ- 8.3.1, ЗГҮАХ- 3.3.3	Дотоодын мах, сүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, хүн амын хэрэгцээнд зориулан нөөц бүрдүүлэх	Сэрүүний улиралд нийлүүлэх түүхий сүүний хэмжээ, сая литр	16.8	24.5	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	
			Ашиглалтад орох сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, фермийн тоо	-	9	6,119.4	Улсын төсөв	ХХААХҮЯ	
			Нөөцөлж, борлуулах махны хэмжээ, мянган тонн	10	15	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	
2.5.3	МУХТЖҮЧ- 8.3.5, ЗГҮАХ- 3.3.8	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, малын гоц халдварт өвчнийг бууруулах	Мал, амьтны халдварт өвчин (гоц болон зооноз өвчнөөс бусад)-ий голомт, тохиолдлын бууралт, хувиар	-	2	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	

			Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	
			Малын бруцеллёз, боом, галзуу зэрэг зооноз өвчний халдварын бууралт, хувиар	-	2	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	
2.5.4	МУХТЖҮЧ-8.3.11, ЗГҮАХ-3.3.1	Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлж, газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг дэмжих	Усалгаатай талбайн хэмжээ, мянган га	56	63	18,000.0	Гадаадын зээл, тусламж	ХХААХҮЯ	СЯ
						2,150.0	Улсын төсөв		
2.5.5	МУХТЖҮЧ-8.3.6, ЗГҮАХ-3.3.1	Газар тариалангийн үр ашгийг нэмэгдүүлэх, үр тариа хадгалах элеватор байгуулах	Бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХХААХҮЯ	
			Ашиглалтад оруулах үр тариа, хүнсний ногооны агуулах, зорины тоо	-	2	3,700.0	Улсын төсөв	ХХААХҮЯ	
Зорилго 2.6. Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.									
2.6.1	МУХТЖҮЧ-1.1.2, 1.1.4, ЗГҮАХ-2.6.1	Соёлын өв, үнэт зүйлийг сурталчлан таниулах музей, театрын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх	"Чингис хаан" хаад, язгууртны шинэ музейн тохижилтын ажлын явц, хувиар	90	100	10,107.0	Улсын төсөв	СоЯ	БХБЯ
			Байгалийн түүхийн шинэ музейн тохижилтын ажлын явц, хувиар	30	40	36,097.6	Улсын төсөв	СоЯ	БХБЯ

			Драммын эрдмийн театрын барилгын хучитгэлийн ажлын явц, хувиар	60	100	1,186.7	Улсын төсөв	СоЯ	БХБЯ
			Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын явц, хувиар	-	100	7,400.0	Улсын төсөв	СоЯ	БХБЯ
			Үндэсний археологи, угсаатны зүйн музей, лабораторийн барилга угсралтын ажлын явц, хувиар	20	40	7,850.0	Улсын төсөв	СоЯ	БХБЯ
2.6.2	МУХТЖҮЧ-8.2.3, ЗГҮАХ-3.4.1	"Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	"Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл I"-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	30	70	29,000.0	Гадаадын зээл, тусламж	Байгаль орчин, аялал жуулчлалын яам /Цаашид БОАЖЯ/	АЗДТГ
			"Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл II"-ийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	-	30				
2.6.3	МУХТЖҮЧ-8.2.1, ЗГҮАХ-3.4.4, 3.4.7, 3.4.8, 4.5.10	Цар тахлын дараах аялал жуулчлалын салбарыг сэргээж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг	Аялал жуулчлалын салбарыг дэмжиж, татах жуулчдыг чиглэлээр хэрэгжүүлэх төслийн хэрэгжилт, жуулчдын тоо	33,000	400,000	-	Улсын төсөв	БОАЖЯ	
			"Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	70	-	Улсын төсөв	ГХЯ	

		хэрэгжүүлж, сурталчилгааг идэвхжүүлэх	"FeelMongolia" аялал жуулчлалын цахим сурталчилгааны хэрэгжилт, хандалтын өсөлтийн хувь	-	20	-	Улсын төсөв	БОАЖЯ	
2.6.4	МУХТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.4.6	Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу түр зогсох цэгийг 100 км тутамд барьж байгуулах	Шинээр байгуулах түр зогсох цэгийн тоо	1	10	18,000.0	Дотоод хөрөнгө оруулалт	ЗТХЯ	СЯ, БОАЖЯ
Бүлэг 3.Иргэн төвтэй хөгжлийг дэмжсэн засаглалын бодлого									
Зорилго 3.1.Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.									
			Татварын тайлагналт, хураалтыг цахимжуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	СЯ	Татварын ерөнхий газар
3.1.1	МУХТЖҮЧ-5.3.2, 5.3.4, ЗГҮАХ-3.1.11, 4.1.1, 4.1.3, 4.5.1, 4.5.3	Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, төрийн үйлчилгээний бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх	Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	50	-	Улсын төсөв	ХЗДХЯ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
			"Цахим архив, албан хэрэг хөтлөлт" хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	-	30	-	Улсын төсөв	ХЗДХЯ	Архивын ерөнхий газар /Цаашид АЕГ/
			"Цахим нэг цонхны үйлчилгээ"-ээр олгох гадаадын хөрөнгө оруулалтын үйлчилгээний тоо	6	16	-	Улсын төсөв	ЭЗХЯ	Холбогдох бусад

			Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (КИОСК) суурилуулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХЗДХЯ	УБЕГ
			Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	12,900.0	Улсын төсөв	ХЗДХЯ	АЕГ
			Цахим виз олгох улсын нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХЗДХЯ, ГХЯ	Гадаадын иргэн харьяатын газар
			Инфляцын түвшинтэй уялдуулан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХНХЯ	СЯ
3.1.2	МУХТЖҮЧ-2.6.5, ЗГҮАХ-2.5.4, 2.5.5	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн албан хаагчдын цалин хөлсний системийг бүтээмж, ажлын үр дүнтэй уялдуулан шинэчилж, цалин хөлсийг нэмэгдүүлэх	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, чанарыг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах гүйцэтгэлийн удирдлагын систем мэдээллийн систем нэвтрүүлэх арга хэмжээний хэрэгжилт хувиар	-	100	-	Улсын төсөв	СЯ, ХНХЯ, ТАЗ	Холбогдох бусад

3.1.3	МУХТЖҮЧ- 5.6.2, ЗГҮАХ- 4.2.1	Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Холбогдох бусад
3.1.4	МУХТЖҮЧ- 5.4.5, ЗГҮАХ- 4.2.1	Зарим төрлийн төрийн хяналт шалгалтыг зогсоож, зөвлөн туслах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Холбогдох бусад
3.1.5	МУХТЖҮЧ- 4.2.5, ЗГҮАХ- 4.1.5	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх	Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төслийн хэрэгжилт, хувиар	-	20	Гадаадын зээл, тусламж	Холбогдох бусад
			Шинээр үүрэн холбооны дамжуулах сүлжээнд холбох суурин газрын тоо	-	5	Улсын төсөв	Холбогдох бусад
Зорилго 3.2. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.							
3.2.1	МУХТЖҮЧ- 7.2.3, ЗГҮАХ- 4.3.1	Улсын хамгаалах салбарын байгууламжийн шинэтгэл хийж, техник технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улсын хил хамгаалалтын зориулалтын инженер, техникийн байгууламжийг шинэчлэх ажлын явц, хувиар	-	100	Улсын төсөв	ХХЕГ
3.2.2	МУХТЖҮЧ- 7.4.1, ЗГҮАХ- 4.3.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан илрүүлэх, таслан	Төвлөрсөн эрчим хүчинд холбогдох хилийн салбарын тоо	-	2	Улсын төсөв	ХХЕГ
			Камерын хяналтын төв байгуулах аймгийн тоо	-	10	Гадаадын зээл, тусламж	Цагдаагийн ерөнхий газар

		зогсоох тогтолцоог бэхжүүлж, дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх	Хууль сахиулах байгууллагын шинэчлэх барилгын тоо	-	14	26,022.0	Улсын төсөв	ХЗДХЯ	
3.2.3	МУХТЖҮЧ-6.4.3, ЗГҮАХ-4.3.11	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг бэхжүүлэх хүрээнд аврах ажиллагаа явуулах нөхцөлийг сайжруулах	Гамшгаас хамгаалах техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хэрэгжилт, хувиар	50	80	19,000.0	Гадаадын зээл, тусламж	Шадар сайдын ажлын алба	Онцгой байдлын ерөнхий газар
3.2.4	МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-4.3.2	Дулааны цахилгаан станц, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг дотоодын цэргийн хамгаалалтад авах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	ХЗДХЯ	
Зорилго 3.3.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.									
3.3.1	МУХТЖҮЧ-7.1.1, ЗГҮАХ-4.6.4	Барилга-инженерийн цэргийн ангийг шинээр байгуулах	Байгуулах ангийн тоо	-	2	-	Улсын төсөв	Батлан хамгаалахын яам /Цаашид БХЯ/	Зэвсэгт хүчний Жанжин штаб /Цаашид ЗХЖШ/
3.3.2	МУХТЖҮЧ-7.1.4, ЗГҮАХ-4.6.7	Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлж, технологи, инновацыг нэвтрүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	10	35	-	Улсын төсөв	БХЯ	ЗХЖШ
Бүлэг 4.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого									
Зорилго 4.1.Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.									

4.1.1	МУХТЖҮЧ-6.2.5, ЗГҮАХ-5.1.5	Ойжуулах, сэргэн байгалийн ургалтыг дэмжих, ойн хомсдол, доройтлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулах талбайн хэмжээ, мянган га	4.9	9	-	Улсын төсөв	БОАЖЯ	АЗДТГ
			Ойн хөнөөлт шавж, өвчний голомттой тэмцэх талбайн хэмжээ, мянган га	33.9	150				
			Ой зохион байгуулалт хийх талбайн хэмжээ, мянган га	1,600	1,800				
			Ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мянган га	32	36				
4.1.2	МУХТЖҮЧ-6.3.2, ЗГҮАХ-5.1.11	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Онги, Хэрлэн усан цогцолбор барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	905,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	БОАЖЯ	УУХҮЯ, ХХААХҮЯ, ЭХЯ
4.1.3	МУХТЖҮЧ-6.2.4, ЗГҮАХ-5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Нөхөн сэргээх талбайн мянган га	-	2	40,000.0	Дотоод хөрөнгө оруулалт	УУХҮЯ, БОАЖЯ	АШИГТ малтмал, газрын тосны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, АЗДТГ
4.1.4	МУХТЖҮЧ-6.2.1,	Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах,	Цөлжилтийг сааруулах арга	200	400	1,290.0	Улсын төсөв	БОАЖЯ	АНЗДТГ

	ЗГҮАХ-5.1.5	хамгаалалтын зурвас байгуулах	хэмжээ хэрэгжүүлэх талбайн хэмжээ, га								
4.1.5	МУХТЖҮЧ-6.3.3, ЗГҮАХ-5.1.3	Хүн амын унд, ахуйн ус хангамжийн нөөц тогтоох хайгуул судалгаа хийх	Нөөц тогтоох сумын төвийн тоо	2	5	1,800.0	Улсын төсөв	БОАЖЯ	АНЗДТГ		
4.1.6	МУХТЖҮЧ-6.3.1, ЗГҮАХ-5.1.2	Хөвсгөл нуурт живсэн машин техникийг татаж гаргах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	20	60	-	Улсын төсөв	БОАЖЯ	ОБЕГ, Усны газар		
4.1.7	МУХТЖҮЧ-2.5.3, 9.2.1, ЗГҮАХ-5.1.1	Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	Агаар дахь РМ 2.5, РМ10 тоосонцрын агууламжийн хэмжээ, мкг/м3	РМ 2.5-44 мкг/м3, РМ10-89 мкг/м3	РМ 2.5-39 мкг/м3, РМ10-78 мкг/м3	-	Улсын төсөв	БОАЖЯ	Холбогдох бусад		
4.1.8	МУХТЖҮЧ-6.4.2, ЗГҮАХ-5.1.12	Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангах	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	-	Улсын төсөв	БОАЖЯ	Холбогдох бусад		

Бүлэг 5.Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

Зорилго 5.1.Хот, хөдөөгийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, амьдрах таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

5.1.1	МУХТЖҮЧ-9.3.2, ЗГҮАХ-3.7.9, 6.1.3	Улаанбаатар хотын гэр хорооллыг дахин төлөвлөж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлэх	"Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	10	100	-	Орон нутгийн төсөв	НЗДТГ			
						252,658.5	Гадаадын зээл, тусламж	НЗДТГ			
					30	36,728.0	Гадаадын зээл, тусламж	НЗДТГ		БХБЯ	

			“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийн явц, хувиар	-	10	15,300.0	Улсын төсөв	БХБЯ	Холбогдох бусад
5.1.4	МУХТЖҮЧ-9.3.4, ЗГҮАХ-6.1.6	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх	Арга хэмжээний хэрэгжилт, хувиар	10	100	420,000.0	Орон нутгийн төсөв	НЗДТГ	ЗТХЯ
			Улаанбаатар хотын ус хангамжийг урт хугацаанд тогтвортойгоор нэмэгдүүлэх төслийн явц, хувиар	15	45	369,000.0	Гадаадын зээл, тусламж	БХБЯ	НЗДТГ
5.1.5	МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3, ЗГҮАХ-6.1.10	Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төслийн явц, хувиар	40	90	108,000.0	Гадаадын зээл, тусламж	БХБЯ	НЗДТГ
			Улаанбаатар хотын инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар	-	100	3,106.5	Улсын төсөв	НЗДТГ	БХБЯ
			Хот доторх авто зам шинээр барих, өргөтгөх ажлын явц, хувиар						
5.1.6	МУХТЖҮЧ-9.2.4, ЗГҮАХ-6.1.7	Хот доторх авто зам, явган хүний зам болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлж,	Шинээр барих дугуйн замын урт, км	-	30	-	Орон нутгийн төсөв	НЗДТГ	БХБЯ
			Шинээр барих явган хүний замын урт, м2	-	150,000	-	Орон нутгийн төсөв	НЗДТГ	БХБЯ

		иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах	Гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар	-	100	41,098.7	Улсын төсөв	НЗДТГ	БХБЯ
Зорилго 5.2.Бүс, орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.									
5.2.1	МУХТЖҮЧ-8.1.10, 9.3.3, ЗГҮАХ-3.7.11, 6.2.7	Орон нутаг дахь сум, суурин газрын ус хангамж, ариутгах татуурга, инженерийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх	Аймгийн төв, суурин газрын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийн явц, хувиар	10	80	22,000.0	Гадаадын зээл, тусламж	БХБЯ	
			"Сумын хөгжил" арга хэмжээний хүрээнд инженерийн дэд бүтэц байгуулах сумын тоо	5	18	31,800.0	Улсын төсөв	БХБЯ	АНЗДТГ
			Инженерийн шугам, үерийн ус зайлуулах шугам, цэвэр бохир усны шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлын явц, хувиар	-	100	130,772.6	Улсын төсөв	БХБЯ	АНЗДТГ
			Төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээг хяналт удирдлагын ухаалаг нэгдсэн системд холбох ажлын явц, хувиар	-	100	-	Улсын төсөв	БХБЯ	
5.2.2	МУХТЖҮЧ-8.1.11, ЗГҮАХ-3.6.1, 3.6.2	Бүс, орон нутгийн хөгжил, аялал жуулчлалыг дэмжих авто зам барих төслүүдийг хэрэгжүүлэх	Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар	26.5	100	85,500.0	Гадаадын зээл, тусламж	ЗТХЯ	СЯ
			Норовлин-Баян-Уул-Ульхан чиглэлийн 121 км хатуу хучилттай авто	-	30	30,220.0	Улсын төсөв	ЗТХЯ	СЯ

5.2.3	МУХТЖУЧ-8.1.10,	Сум, суурин доторх авто зам, хүүхдийн	Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийг замыг Мөрөн-Тариалан чиглэлийн авто замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто зам барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	77,122.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	ЗТХЯ	СЯ
			Хялганат-Хангал чиглэлийн эхлэлийн хатуу хучилттай 10 км авто замын барилгын ажлын явц, хувиар	-	100	2,000.0	Улсын төсөв	ЗТХЯ	
			Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай 122.4 км авто замын барилгын ажлын явц, хувиар	-	25	33,620.9	Улсын төсөв	ЗТХЯ	
			Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто замын барилгын ажлын явц, хувиар	-	100	9,375.3	Улсын төсөв	ЗТХЯ	
			Ховд-Алтай чиглэлийн авто замаас Чандмань сум хүртэлх хатуу хучилттай 56.9 км авто замын барилгын ажлын явц, хувиар	-	100	34,339.0	Улсын төсөв	ЗТХЯ	
			Сум, суурин доторх авто зам шинээр	-	100	165,161.7	Улсын төсөв	ЗТХЯ	

9.3.4, ЗГҮАХ- 6.2.7	тоглоомын талбай, ногоон байгууламж, гудамж гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тав тухтай амьдрах орчныг сайжруулах	барих, өргөтгөх ажлын явц, хувиар Сум, суурин доторх гудамж, талбайн тохижилт хийх ажлын явц, хувиар Аймгийн төвүүдэд байгуулах зорчигч тээврийн авто буудлын тоо	-	14	52,787.4	Улсын төсөв	БХБЯ	АНЗДТГ
			-	1	3,000.0	Улсын төсөв	ЗТХЯ	

---0000000---